

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011.03.25

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас тайлангийн хугацаанд төрийн залгамж чанарыг хадгалан тухайн үеийн шаардлага, нөхцөл байдалд нийцүүлэн жил бүрийн онцлогт тохирсон тодорхой зорилтуудыг аймгийн 2010 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон бодлогын бусад баримт бичигт тусган тодорхойлж, амжилттай хэрэгжүүлэв.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар 2010 оныг аймаг орчноо тохижуулах жил болгон зарлаж, аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн нэрэмжит 80 бүтээлч ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, малчдын талаар баримтлах аймгийн бодлого, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны 2011-2014 оны хэтийн төлөвлөгөө, эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, айл, өрх бий болгох, хүнсний баталгаат байдал, сүү, чацаргана, аялал жуулчлал аймгийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлуулан мөрдөж ажилласан нь аймгийн хөгжлийн бодлогын гол цөм болж байна.

2010 онд аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт, аймгийн малчдын болон хүнс, уул уурхай эрхлэгчдийн зөвлөлгөөнийг зохион байгуулж, төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг өндөржүүлж, авилга, хүнд суртлаас ангид байлгах, төрийн байгууллагын үйл ажиллагааны чанар, үр нөлөө, шуурхай ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тавьж, хэрэгжүүлж ажиллав.

2010 онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд 21.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 52.8 хувь нь буюу 11.5 тэрбум нь улсын төсвийн хөрөнгө, 2.0 хувь буюу 0.4 тэрбум нь орон нутгийн төсвийн хөрөнгө, 21.0 хувь буюу 4.6 тэрбум нь гадаадын хөрөнгө оруулалт, 24.1 хувь буюу 5.2 тэрбум нь банкны зээл болон сумдын өөрийн хөрөнгө, иргэдийн хөрөнгөөр тус тус с анхүүжигдсэн байна. Хөрөнгө оруулалтын ажлын 59.2 хувийг барилга угсралт, их засварын ажилд, 19.7 хувийг зам засвар, арчлалтын үйл ажиллагаанд, 7.7 хувийг худаг гаргах, дулааны шугамын засвар, гэрэлтүүлэгт, 13.4 хувийг бусад үйл ажиллагаануудад зарцуулсан байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ урьдчилсан байдлаар 92.5 тэрбум төгрөг, 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 825.0 төгрөг байна. Аж үйлдвэрийн салбарт 5973.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оны үнээр 5619.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 28.5, борлуулалт 29.0 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн төсөвт 2010 онд 4.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 105.7 хувьтай байгаа нь орлого өнгөрсөн оноос 10.3 хувиар нэмэгдсэн байна.

Иргэд, байгууллагын мөнгөн хадгаламж 24.2 тэрбум төгрөг болж, аймгийн 1 хүнд дунджаар 215.7 мянга, 1 хадгаламж эзэмшигчдэд 707.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байгаа бөгөөд өнгөрсөн оноос хадгаламж эзэмшигчийн тоо 23.4, хадгаламж 29.1 хувиар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор улсаас 136.9 мянган хүнд 15.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, аймгийн худалдаа, нийтийн хоолны цэг, салбарууд 24.0 тэрбум төгрөгийн бараа, гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 8.6 хувиар өслөө. Сүүлийн 2 жилд Өвөрхангай аймагт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 15.0 тэрбум гаруй төгрөгийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэв.

2010 оныг аймаг “Бүтээн байгуулалт, орчноо тохижуулах жил” болгон зарлаж иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн болзол гарган дүгнэж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12.0 гаруй тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж, Арвайхээр суманд 600 хүний суудалтай “Спортын ордон”, “Гэр бүл, хүний хөгжлийн төв-Гэрлэх ёслолын ордон,” Бат-Өлзий, Хайрхандулаан сумдад 75 ортой хүүхдийн цэцэрлэг шинээр барьж, 42.0 км хатуу хучилттай зам шинээр тавьж ашиглалтад хүлээн авлаа.

Улс, аймгийн түвшинд эдийн засгийн чадавхи нэмэгдэх хандлагатай байгаа боловч ялангуяа орон нутагт төсвийн орлогод нөлөө үзүүлэх томоохон аж ахуйн нэгж бий болж төлөвшөөгүй, эдийн засгийн үндсэн салбар МАА, газар тариалангийн үйлдвэрлэлд байгаль, цаг уураас хамааралтай уналт үргэлжилсээр байна.

Аймгийн 2010 оны хөгжлийн бодлогын үндсэн баримт бичиг болох “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэл”-д 8 бүлэгт хамаарах 129 зорилт, арга

хэмжээг тусган тодорхойлж, баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажилласнаар 93.1 хувьтай биелэгдэж, “Хангалттай” гэсэн үнэлгээг аймгийн ИТХ-аас өглөө.

А. ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

1. Хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын үзэл баримтлал, зорилттой уялдуулан Өвөрхангай аймаг Хөгжлийн эрхэм зорилгоо "Хүн бүр ажил хөдөлмөр эрхэлж, аймгийнхаа нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх явдал мөн" гэж тодорхойлж, энэхүү эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд "Хөгжлийн төлөө харилцан бие биеэ дэмжин тусла" гэсэн зарчим баримтлан ажиллаж байна.

Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого /2007-2015/-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2006 онд хэлэлцэн батласан бөгөөд Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичиг 2008 онд Улсын Их Хурлаар батлагдсантай уялдуулан “Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2009 онд шинээр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, өөрсдийн нөөц баялаг, боломжид тулгуурлан тодорхойлж, аймгийн дунд, богино хугацааны салбарын хөтөлбөрүүдийг боловсруулж байна. Энэ нь цогц бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний зохион байгуулалт, чиглэлийг тодруулж, хэрэгжилтийг эрчимжүүлж байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэгч талууд болох төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, төр-иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэн, гурван талт түншлэлийг хөгжүүлэх зорилт дэвшүүлж, энэхүү зорилтын хүрээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын чиглэл гарган, 2010 онд 18.8 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын зургаан тэргүүлэх чиглэлийн стратегийн зорилтуудыг Өвөрхангай аймаг бодлогын баримт бичгүүддээ хэрхэн тусган, зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж буйг харьцуулан дүгнэхэд хялбар байдлаар хүснэгтлэж, хэрэгжилтийг хавсарган гаргалаа.

2. Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ

Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийг “Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат”-ыг үнэлэх нэгдүгээр шатны үзүүлэлт болон Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй харьцуулан дүгнэлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж, бодлого зохицуулалтаар дэмжсний үр дүнд аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 790 гаруй иргэн, аж ахуй нэгжийн бизнесийн эрх зүйн орчин сайжирч, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2009 оны байдлаар 4650.0 сая төгрөг байсан бол 2010 оны байдлаар 5973.5 сая төгрөг болж, үйлдвэрлэлт 28.5, борлуулалт 29.0 хувиар өссөн байна.

2010 онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд 21.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 52.8 хувь нь буюу 11.5 тэрбум нь улсын төсвийн хөрөнгө, 2.0 хувь буюу 0.4 тэрбум нь орон нутгийн төсвийн хөрөнгө, 21.0 хувь буюу 4.6 тэрбум нь гадаадын хөрөнгө оруулалт, 24.1 хувь буюу 5.2 тэрбум нь банкны зээл болон сумдын өөрийн хөрөнгө, иргэдийн хөрөнгөөр тус тус санхүүжигдсэн байна.

2008-2012 онд 10000 ажлын байр шинээр бий болгох зорилт дэвшүүлэн 2009-2010 онд ажлын байр 5736-г бий болгоод байна.

Бага боловсролд хамрагдвал зохих 6-14 насны 10448 хүүхдээс 10030 нь ЕБС-д суралцаж, хамран сургалт 96 хувьтай байна. 2009-2010 оны хичээлийн жилд стандартын хэрэгжилт бага боловсролд 98%, суурь боловсролд 98%, бүрэн дунд боловсролд 99.7%, аймгийн дүнгээр 98.5%-тай үнэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхоос тус бүр 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2012 он гэхэд хүн амын хүнсний хэрэгцээт мах, гурил, төмсийг 100 хувь, сүү, хүнсний ногооны 90.0 хувийг эх орны болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж, импортын төмс, хүнсний ногооны хэрэглээг 30.0 хувиар бууруулах зорилт дэвшүүлэн

ажилласнаар аймгийн хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээт махны 165.6, гурилын 85.0, төмсний 77.8, сүү, сүүн бүтээгдэхүүний 59.2, хүнсний ногооны 20.3 хувийг эх орны болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр тус тус хангаж байгаа бөгөөд үүнээс мах 165.6, гурил 2.9, сүү, сүүн бүтээгдэхүүн 24.4, төмс 47, хүнсний ногоо 19.1 хувиар тус тус өөрийн орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Үүний үр дүнд импортын төмс, хүнсний ногооны хэрэглээ 11.3 хувиар буурсан дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилд нийт 916.0 с.ж төгрөгийн санхүүжилтээр 37 инженерийн худаг шинээр гаргаж, 11 худаг сэргээн засварлан, 25 гар худаг шинээр гаргаж, 142.4 мянган га бэлчээрийн болон тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлээд байна.

Богд сумаас бусад бүх сумд эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон ба энэ онд тус сумыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбохоор улсын төсөвт хөрөнгө нь тусгагдаад байна. Үндэсний хөгжлийн цогц бодлогыг орон нутгийн бодлого зорилтуудтай уялдуулснаар 2010 оны хэрэгжилт нь 95.8 хувьтай байна.

Б. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан аймаг, орон нутагт хамааралтай 5 багц, 18 салбарт хэрэгжих 95 зорилт, 174 арга хэмжээг түүвэрлэн нэгтгэж, дээрх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах, биелэлтийг тооцож, дүгнэх, мэдээлж тайлагнах ажил, үүргийн хуваарийг боловсруулан баталгаажуулж, зорилт, арга хэмжээ нэг бүрийг аймгийн ЗДТГ-ын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, ажилтнуудад хуваарилан хариуцуулж эзэнжүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд аймаг, орон нутгийн эдийн засгийн чадавх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, нээлттэй болгох зэрэг зорилтуудыг шийдвэрлэх талаар ажлын тодорхой ахиц өөрчлөлт гарлаа.

Нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тодорхой давтамжтайгаар хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг оролцооны аргаар үнэлэх, засаг захиргааны анхан шатны нэгж багийг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан нь төрийн албаны ажил, үйлчилгээг төлөвшүүлэн тогтмолжуулах, төр-иргэний холбоог бэхжүүлэхэд бодитой ахиц, өөрчлөлт гарсан гэж үзэж болно.

Нутгийн удирдлагын болон захиргааны байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгоход төрийн үйлчилгээний байгууллагуудын нэг цэгийн, нэг цонхны үйлчилгээ, нээлттэй хаалганы өдөр, сум, байгууллагуудын сурталчилах өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд ажлаа мэдээлж тайлагнах, иргэдээс санал, хүсэлт, үнэлгээ, дүгнэлт хүлээн авах, саналын хайрцаг ажиллуулах зэрэг олон хэлбэрийн ажил зохион байгуулсан нь төрийн ажил, үйлчилгээний хүртээмж, чанарт эерэгээр нөлөөлөв.

2010 онд Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд үндэслэн Өвөрхангай аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулах ойн нэрэмжит 80 бүтээлч ажлыг хэрэгжүүлэх ажил аймаг, сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүрээнд эрчимтэй өрнөж байна.

Тухайн жилд дэвшүүлсэн бодлогын зорилтын хүрээнд ажлын үр дүн чамлахааргүй байгаа ч иргэд төр засгаас ажлын тодорхой үр дүн, төрийн хүртээмжтэй, чанартай үйлчилгээ, айл өрх, иргэн бүрийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны баталгааг хангахуйц хэмжээний бодитой, тодорхой ажил, үйлчилгээ, ёс зүй, шударга ёсны өндөр хэм хэмжээг шаардсаар байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний аймаг, орон нутагт хамааралтай бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг тооцож, дүгнэхдээ 2009 онд 30.0 хувь, 2010 онд 60.0 хувь, 2011 онд 90.0 хувь, 2012 онд 100.0 хувь буюу бүрэн хэрэгжсэн байхаар урьдчилан тооцсон болно. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үнэлгээ 57.2 хувь, тухайн жилийн буюу 2010 оны хэрэгжилтийн үнэлгээ 95.3 хувьтай байна.

В. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан Өвөрхангай аймагт хэрэгжиж байгаа орон нутгийн хөгжил, төрийн удирдлагын салбарын 4, хууль, эрх зүйн салбарын 6, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн салбарын 4, боловсрол, соёлын салбарын 10, эрүүл мэндийн салбарын 8, хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн салбарын 9, дэд бүтэц, үйлдвэрлэл-үйлчилгээний салбарын 5, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 12 нийт 8 салбарын хүрээнд хэрэгжиж байгаа 58 үндэсний хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэлт гаргалаа.

Үндэсний хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр: орон нутгийн хөгжил, төрийн удирдлагын салбар 95.0, хууль, эрх зүйн салбар 91.7, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн салбар 91.7, боловсрол, соёлын салбар 96.0, эрүүл мэндийн салбар 92.0, хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн салбар 95.0, дэд бүтэц, үйлдвэрлэл-үйлчилгээний салбар 88.0, байгаль орчин, аялал жуулчлалын салбар 90.7, аймгийн хэмжээнд 8 салбарын хүрээнд хэрэгжиж байгаа 58 үндэсний хөтөлбөрийн 380 заалтыг хяналтад авч, хувийн хэрэг нээж, хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилт 92.5 хувийн дундаж үнэлгээтэйгээр дүгнэгдэв. Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан Өвөрхангай аймагт хэрэгжиж байгаа 58 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2010 оны үйл ажиллагаанд 8593.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Тайлант онд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-аас сумдад зөвлөн туслах чиглэлээр аймгийн ажлын хэсэг ажиллуулж, сургалт-семинар зохион байгуулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн ээлжит хурлаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хугацаа, үе шат нь дуусч байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнгийн талаархи асуудлыг 2 удаа хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт гаргаж ажилласан нь 2010 оны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэв. Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ХШҮТасаг тайлант онд УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдан аймаг, орон нутагт 8 салбарын хүрээнд хэрэгжиж байгаа 58 үндэсний хөтөлбөрийн судалгааг шинэчлэн гаргаж, хөтөлбөр нэг бүрийг аймгийн ЗДТГазрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, ажилтнуудад хуваарилан хариуцуулж, эзэнжүүлэн, удирдлага, зохицуулалтаар хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож, дүгнэх үйл ажиллагаа төлөвшиж тогтмолжлоо.

Үндэсний хөтөлбөрийн 2010 оны хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс дүгнэлт хийхэд: Үндэсний хөтөлбөрийн зохицуулагч буюу хөтөлбөр хариуцсан ажилтантай, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэртэй байгаа эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилт, ялангуяа үр дүн бусад салбарын хөтөлбөрүүдээс харьцангуй сайн байхад дэд бүтэц, үйлдвэрлэл-үйлчилгээний болон байгаль орчны салбарын зарим хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй дүгнэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд тайлант онд Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих, төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх, боловсрол, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах, үдийн цай, халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сүү, чацаргана, хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2, нэг суурин-нэг бүтээгдэхүүн, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх, ойн тухай зэрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалттай сайн байхад хүн амыг эрүүл ахуйн шаарлагад нийцсэн ундны усаар хангах, ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих, удаан задардаг органик бохирдуулагчийн тухай зэрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй дүнтэй үнэлэгдлээ.

УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдан аймаг, орон нутагт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүд нь дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд дийлэнх хөтөлбөрүүд нь хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, ажилтан эзэн тодорхойгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож, үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт байхгүй байгаа зэргээс шалтгаалан хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна.

Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгтгэж боловсруулахдаа аймгийн ЗДТГ-ын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлагууд сум, орон нутаг ялангуяа байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулан хийж, хэрэгжүүлж байгаа бодит ажил, үйлчилгээ, арга хэмжээг бүрэн хамруулж чадахгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээнд нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна.

ХОЁР. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

А. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2010 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан аймаг, сум, орон нутагт хамааралтай 6 багцад хэрэгжих 195 зорилт, арга хэмжээг түүвэрлэн нэгтгэж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах, биелэлтийг тооцож, дүгнэх, мэдээлж тайлагнах ажил, үүргийн хуваарийг боловсруулан баталгаажуулж, зорилт, арга хэмжээ нэг бүрийг аймгийн ЗДТГазрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, ажилтнуудад хариуцуулан эзэнжүүлж ажиллаж байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймаг, орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр: макро эдийн засгийн бодлого 98.4, бодит салбарын хөгжлийн бодлого 97.2, байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого 96.2, ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлого 95.4, гадаад бодлого, батлан хамгаалах 95.6, засаглал, эрх зүйн шинэчлэл 96.5 хувь буюу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт дүнгээрээ 96.4 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж, бодлого зохицуулалтаар дэмжсний үр дүнд аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 790 гаруй иргэн, аж ахуй нэгжийн бизнесийн эрх зүйн орчин сайжирч, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2009 оны байдлаар 4650.0 сая төгрөг байсан бол 2010 оны байдлаар 5973.5 сая төгрөг болж үйлдвэрлэлт 28.5%-иар, борлуулалт 29.0 %-иар өссөн байна.

Тайлант онд 650.0 сая төгрөгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 213.0 сая төгрөгийн санхүүжилтээр 22 үйлдвэр шинээр байгуулагдаж, 45 үйлдвэр, үйлчилгээний газрууд 437.0 сая төгрөгөөр эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх, үйлдвэрийн байртай болохын зэрэгцээ 129 ажлын байр шинээр бий болж, жижиг, дунд үйлдвэрийн салбарт ахиц гарлаа.

2010 онд тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 12.0 гаруй тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдээд байгаа бөгөөд Арвайхээр суманд 600 хүний суудалтай Спорт ордоны барилгын ажлыг 1532.1 сая төгрөгөөр, Бат-Өлзий, Хайрхандулаан суманд тус бүр 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 700.0 сая төгрөгөөр, Арвайхээр суманд Хуримын ордоны барилгын ажлыг 460.0 сая төгрөгөөр, Арвайхээрт 1100 метр хатуу хучилттай авто зам барих ажлыг 360.0 сая төгрөгөөр, Хархорин сумын төвд 600 метр хатуу хучилттай авто зам барих ажлыг 200.0 сая төгрөгөөр, аймгийн Шүүхийн барилгын өргөтгөлийг 289.0 сая төгрөгөөр, Хархорин суманд Цагдаагийн хэлтсийн барилгыг 850.0 сая төгрөгөөр тус тус барьж байгуулан ашиглалтанд хүлээн аваад байна.

Дээрхи бүтээн байгуулалтын ажлуудаас гадна Уянга суманд 400 хүний суудалтай Соёлын төвийн барилга 910,0 сая төгрөгөөр, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга 1530,0 сая төгрөгөөр, Арвайхээр суманд 150 ортой Цэцэрлэгийн барилга 650,0 сая төгрөгөөр тус тус баригдаж ирэх онд ашиглалтанд оруулахаар зорилт тавин ажиллаж байна.

Мөн Хархорин-Хужиртын чиглэлийн 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16.4 км хатуу хучилттай авто зам, Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн 5.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 27 км хатуу хучилттай авто зам барих ажлууд төлөвлөгөөт хугацааны дагуу хийгдэж байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл амжилттай хэрэгжиж аймаг, орон нутгийн ерөнхий нүүр царай, өнгө төрх шинэчлэгдэн сум, баг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн ажил, амьдрал, үйл ажиллагаанд тодорхой ахиц дэвшил гарсан жил байлаа.

Б. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газраас баримталж байгаа үр дүнд суурилсан удирдлага, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх бодлогын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчин, тогтолцоог төгөлдөршүүлэх, нутгийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшлүүлэх талаар тодорхой зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, дэвшүүлсэн бодлого, зорилтынхоо үр дүнг тооцон үнэлж дүгнэлээ.

2010 онд УИХ, Засгийн газрын болон аймгийн ИТХ-ын 135 тогтоол, шийдвэрийн 229 заалтыг хяналтад авч, цахим сан бүрдүүлэн, эзэнжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцох, мэдээлэх ажлыг журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийн явцын тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн ажиллаж байна. 2010 оны 4 дүгээр улирлын байдлаар 95 тогтоол шийдвэрийн 144 заалтыг хэрэгжүүлэн зохион байгуулсны үр дүнд тогтоол, шийдвэрийг хэрэгжилт 94.3 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 408 дугаар захирамжаар “Хууль, тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, үр дүн, гүйцэтгэлийг мэдээлэх журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна.

“Сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 03 дугаар албан даалгаврын биелэлтийг сар бүрийн 10-ны дотор аймгийн ЗДТГ-ын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын ЗДТГ-аас гаргуулан нэгтгэж ЗГХЭГ-т хүргүүлээ.

“Хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн ИТХурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцон ажиллах чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын тухай Нарийнтээл сумын Засаг даргын сонсголыг, аймгийн Засаг даргын 2009 оны “Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, явц үр дүнгийн тухай Богд сумын Засаг даргын мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгч ажилласнаар дээрх сумдын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцох, хяналт тавих, мэдээлэх тайлагнах ажил журмын дагуу явагдаж үр дүнд хүрлээ.

Засгийн газрын 2010 оны 137 дугаар тогтоолын биелэлт болон 2010-2011 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаар аймгийн Засаг дарга нь Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хийж, аймаг, орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг танилцуулан шийдвэрлүүлж, Засгийн газраас шийдвэр гаргуулан ажиллав.

Аймгийн ЗДТГазрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, сумдын ЗДТГазраас ирүүлсэн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүн, мэдээнд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дүнгийн тухай танилцуулга, үнэлгээг сум, байгууллага бүрээр гарган хүргүүлж, зөвлөмж, чиглэл өгч, Уянга, Тарагт, Бүрд, Гучин-Ус суманд хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг сайжруулах үүргийг Засаг дарга нарт мэдэгдэн, мэдээлэл солилцон эргэх холбоотойгоор ажиллаж ирлээ.

2010 оны 05 дугаар сард сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Төрийн захиргааны ажилтнуудыг оролцуулсан нэгдсэн сургалтыг зохион байгуулан, Төрийн албаны шинэчлэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй, Үндэсний хөтөлбөр, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, мэдээлэх, албан хэрэг хөтлөлтийн зааврын тухай сэдвүүдээр 2 өдрийн сургалт зохион байгууллаа.

Орон нутагт хууль тогтоомж, Засгийн газрын болон аймгийн ИТХурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх сургалтыг Нарийнтээл, Богд, Бүрд, Баруунбаян-Улаан, Хархорин, Баян-Өндөр сумдад явуулж, эдгээр сумдын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж буй ажлын явц, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж, заавар зөвлөмж өгч ажиллав.

2010 онд Засгийн газрын 1996 оны 66 дугаар тогтоолд заасны дагуу албан байгууллагын удирдлага хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх нийтэд сурталчлахтай холбогдсон чиг үүргийг төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт тусган хэрэгжүүлэх ажил 2009 онд хангалтгүй байгаад дүгнэлт хийж, 2010 онд нийт төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусган ажилласнаар хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах ажил тодорхой үр дүнд хүрлээ.

Тогтоол шийдвэрийн цахим санг аймгийн ЗДТГазрын хэлтсүүд, агентлагуудын хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу бүрдүүлж, Хүүхдийн төлөө хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Боловсрол соёлын газар, Онцгой байдлын хэлтэс, Төгрөг, Тарагт, Хужирт, Нарийнтээл, Ёсөнзүйл, Зүүнбаян-Улаан, Бүрд, Гучин-Ус, Хархорин сумдын ЗДТГазарт хүргүүлж, арга зүйгээр хангаж ажиллаа.

ХХААХҮСайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаар хяналт-шинжилгээ хийлгүүлэн, хэрэгжилтийг үнэлүүлэх шаардлагыг тавьсан нь үр дүнгээ өгч, бодитойгоор үнэлэгдэх боломж бүрдэн, яам, аймгийн ЗДТГ-ын ажлын уялдаа холбоо сайжирч байгаа тул

цаашид бусад яамдын түвшинд ч хэрэгжүүлэхэд ЗГХЭГ-ын зүгээс анхааран яамдын түвшинд уг саналыг танилцуулах нь зүйтэй байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүн, биелэлтийг дүгнэн ажиллаж ЗГХЭГ-т улирал бүр хүргүүлэн ажиллаж байна. Орон нутгаас хүргүүлсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн дүн, мэдээ, танилцуулгад ЗГХЭГ-аас хяналт-шинжилгээ хийж, алдаа, дутагдлыг тухай бүр мэдээлж, заавар зөвлөмж, чиглэл өгч эргэх холбоотойгоор мэдээлэл солилцон ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолын дагуу Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн танилцуулга, дүн, мэдээг 2010 оны 04 дүгээр улирлын байдлаар гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн тул аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын 2010 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд хавсралтаар гаргаагүй болно.

В. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд аймаг, орон нутгийн эдийн засгийн чадавхи, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод, нээлттэй болгох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн, шийдвэрлэх талаар ажлын тодорхой ахиц өөрчлөлт гарлаа.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Нутгийн удирдлагын чадавхийг дээшлүүлж, орон нутгаа хөгжүүлэх таатай нөхцөлийг хамтын оюун ухаан, хичээл зүтгэлээр бүрдүүлэх"-ийг эрхэм зорилго болгон дэвшүүлсэн билээ.

Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан нь төрийн албаны ажил, үйлчилгээг төлөвшүүлэн, тогтмолжуулах, төр-иргэний холбоог бэхжүүлэхэд өөрчлөлт гарган, төрийн үйлчилгээний байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээ, нээлттэй хаалганы өдөр, сум, байгууллагуудын нээлттэй өдөрлөгийг тогтмол зохион байгуулж, иргэдэд ажлаа тайлагнах, иргэдийн санал, хүсэлтийг сонсч, шүүмжлэлийг хүлээн авч, тэдгээрт дүгнэлт хийж ажилласан нь төрийн ажил, үйлчилгээний хүртээмж, чанарт эерэгээр нөлөөлж байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх, харилцааны соёлыг дээдлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, авилга хээл хахууль архидалтай хатуу тэмцэж ажиллахыг үүрэг болгон, байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан төсвийн байгууллагуудын ерөнхий менежерийн гэрээнд тусган ажиллав.

Аж үйлдвэр, барилга, газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, ахуйн үйлчилгээний шинэ салбаруудад ажиллагсдын тоо өсч 2010 онд 2537 шинэ ажлын байр бий болсон байна.

Мал аж ахуйн салбарт тохиолдсон байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс аймгийн эдийн засаг, ард иргэдийн амьдралд учирсан үлэмж хохирлыг арилгах, малчин түмнийхээ сэтгэл санааг өргөн тэднийг дэмжин цаашид мал аж ахуйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан хамгаалж, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэн улмаар ард олны амьдралийн чадавхийг дээшлүүлэхэд "Монгол мал" үндэсний хөтөлбөр, "Малчдын талаар төрөөс баримтлах бодлого" нь ихээхэн тус дэмжлэг боллоо.

Мал аж ахуйд учирсан хохирлыг арилгах чиглэлээр малжуулах асуудлыг эхний ээлжийн зорилт хэмээн үзэж Засгийн газраас хэрэгжүүлж байгаа малжуулах төслийн нийт хөрөнгө 537.0 сая төгрөгөөр, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төсөлд сумдын 1689 өрхийг хамруулан өрх бүрийг 300.0 мянган төгрөгөөр малжуулахад 506.7 сая төгрөгийн төсөл, Каритас Чех байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Баян-Өндөр сумын 40 өрхийг 2020 толгой малаар малжуулах ажлыг зохион байгууллаа. Малгүй болсон малчдыг бусад салбарт мэргэшүүлэн шилжүүлэх ажлыг сумдын удирдлагуудтай хамтран зохион байгуулж, 15 мэргэжлээр сургалт зохион байгуулж малгүй болсон 452 иргэн хамруулан мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгов. Малгүй болсон 636 малчныг нийтийг хамарсан ажилд хамруулж, 254 түр ажлын байраар хангалаа.

Аймгийн Засаг дарга ард иргэдэд Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг чиглэл тус бүрээр хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, хэрэгжүүлэхээр зорьж буй бодлогуудаа танилцуулав. Уулзалтын үеэр

иргэдийн санал хүсэлтийг сонсч, орон нутгийн Таны элч сонинд тусгай дугаар гарган, 10000 ширхэг хэвлүүлэн иргэдэд тараалаа.

Аймгийн Засаг дарга нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, тогтоомж, шийдвэрийг үйл ажиллагаандаа чандлан сахиж, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2010 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ бүрээр боловсруулан баталж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг хуулинд заасан хугацаанд зарлаж, бараа бүтээгдэхүүн худалдан авах тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласнаар улс болон орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгийн тендерийн ажлыг гүйцэтгүүлээ.

Төсвийн төслийг 3 жилээр, хөтөлбөрт суурилсан байдлаар боловсруулж, төсвийн гүйцэтгэлийн тайланг зориулалт, хөтөлбөрөөр тайлагнах боллоо. Бүх салбарын төсвийг дунд хугацаанд хөтөлбөрт суурилан боловсруулан Сангийн яаманд хүргүүлээ. Төсвийн зарцуулалтад тавих хяналт сайжирч төсөв хэтрэх, өр үүсэх явдал арилж, төсвийн бүх байгууллагууд өргүй гарсан болно. Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер, төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагын нягтлан бодогчдын ажлын үр дүнг үнэлж, урамшуулал олгох, хариуцлага тооцох "Төсвийн хариуцлагын журам"-ыг шинэчлэн батлав.

Засгийн газраас 2010 оныг "Бизнесийн орчны шинэтгэлийн жил" жил, аймгийн ИТХ-аас "Орчны тохижилтын жил" болгон зарлаж, "Аймаг байгуулагдсан 80 жилийн ойг угтан хийх 80 бүтээлч ажлын жагсаалтыг батлан, төсөв, хөрөнгө оруулалтыг зөв хуваарилж өгсөн нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг болсон юм.

Аймгийн төсөвт 4.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 105.7 хувьтай ба өнгөрсөн оноос орлого 10.3 хувиар нэмэгдлээ. Татварын орлогын төлөвлөгөөг 5.6 хувиар, татварын бус орлого 6.1 хувиар тус тус давж биелсэн.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 106.2 хувьтай, орон нутгийн төсвийн урсгал зардлын 71.5 хувийг орон нутгийн орлогоор бүрдүүлээ.

2010 онд аймгийн "Сэтгүүлчдийн нэгдсэн холбоо"-г шинээр байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан төр засгийн үйл ажиллагааг сурталчлан мэдээлэх, ТББ-ууд болон Үйлдвэрчний эвлэлийн салбаруудаас төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх саналыг хүлээн авч гэрээний үндсэн дээр нийт 18.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэн дүгнэхэд, иргэдийн оролцоо нэмэгдсэн, сургалт, үйлчилгээг зорилтот бүлэгт сайтар зохион байгуулсан зэрэг давуу талууд байлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан "Батламж"-ийг үзүүлэлт тус бүрээр гарган дүгнэхэд биелэлт нь 97.5 хувьтай байна. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулсан "Батламж"-ийн биелэлтийг 2010 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 28 шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэхэд 90.8 хувьтай биелэгдсэн байна.

Г. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2010 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2010 оны төсөв, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг туслалцааны өсөлт, зун, намрын таатай нөхцөл, орон нутгийн нөөц боломж, иргэдийн идэвхи санаачилгад тулгуурлан хадлан тэжээл бэлтгэн нөөцлөх, бэлчээр усжуулах, өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, үр тариа, ногоо, жимс жимсгэнэ тариалж, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинээр жижиг, дунд үйлдвэр, цех, ажил үйлчилгээний шинэ шинэ салбарууд байгуулах зэргээр ажлын байрыг нэмэгдүүлж, аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг нэмэгдүүллээ. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн уналтаас болж нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ өссөн тал бий ч үйлдвэрлэл сэргэж, жижиг дунд үйлдвэрлэлүүд нэмэгдэн, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 5619.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 886.7 сая төгрөг буюу 25.6 хувиар өслөө. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарын тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээмж, үр ашиг, бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар дээшилж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аймгийн хэмжээнд оёдол 86.2, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл 72.8, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 20.3, нүүрсний олборлолт 31.7, цахилгаан дулааны үйлдвэрлэл 21.7, хэвлэх үйлдвэр 20.7 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 4.2 тэрбум төгрөгт хүрсний дотор уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 549.5 сая төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 2891.9 сая төгрөг болж өслөө. Үүний үр дүнд аймгийн төсвийн орлогын өсөлт 10.6 буюу өмнөх оноос 3.4 хувиар өссөн байна.

Аж үйлдвэр, барилга, газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, ахуйн үйлчилгээний шинэ салбаруудад ажиллагсдын тоо өсч 2010 онд 2537 шинэ ажлын байр бий болсон байна.

Мал аж ахуйн салбарт тохиолдсон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс аймгийн эдийн засаг, ард иргэдийн амьдралд учирсан үлэмж хохирлыг арилгах, малчин түмнийхээ сэтгэл санааг өргөн тэднийг дэмжин цаашид мал аж ахуйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан хамгаалж, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэн улмаар ард олны амьдралийн чадавхийг дээшлүүлэхэд УИХ-аас батлан хэрэгжүүлж байгаа "Монгол мал" үндэсний хөтөлбөр, "Малчдын талаар төрөөс баримтлах бодлого" нь ихээхэн тус дэмжлэг болж байна. Энэ оноос Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр бүх сумын Засаг даргын Тамгын газрын бүтцэд Мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулагдсан нь төрөөс мал аж ахуйн хөгжил, малчдын талаар явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сумдад хэрэгжүүлэх эзэн, хариуцах мэргэжилтэнтэй болгосон нь нэг алхам болсон байна.

2010 онд "Атрын III ая"-ны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан. Аймгийн хэмжээнд 1716.7 га-д үр тариа тариалж улаан буудайн тариалсан талбай урьд оноос 737 га-аар, ургац 356 тн-оор нэмэгдэж, аймгийн хүн амын хэрэгцээт гурилын 8.1 хувийг үйлдвэрлэхэд шаардлагатай үр тариа хураан авлаа. Аймгийн хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээт махны 165.6, гурилын 85, төмсний 77.8, сүү, сүүн бүтээгдэхүүний 59.2, хүнсний ногооны 20.3 хувийг эх орны болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр тус тус хангаж, импортын төмс, хүнсний ногооны хэрэглээ 11.3 хувиар буурсан дүнтэй байна. Аймгийн нийт хүн амын хүнсний хэрэгцээт мах, гурил, төмсийг 100 хувь, сүү, хүнсний ногооны 90.0 хувийг эх орны болон орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах аймгийн Засаг даргын хөтөлбөрийн зорилт 2012 онд бүрэн хэрэгжих боломж бүрдэж байна. Аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилд нийт 916.0 сая төгрөгийн санхүүжилтээр 37 худаг шинээр гаргаж, 11 худаг сэргээн засварлан, 25 гар худаг шинээр гаргаж, 142.4 мянган га бэлчээрийн болон тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлээд байна.

Засгийн газраас 2010 оныг "Биенесийн орчныг сайжруулах" жил, аймгийн ИТХ-аас "Орчноо тохижуулах жил" болгон зарлаж, аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтаж хийх 80 бүтээлч ажлын жагсаалтыг баталж, төсөв, хөрөнгө оруулалтыг зөв хуваарилж өгсөн нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг боллоо.

Аймагт 2010 онд улсын болон орон нутгийн төсвийн, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 14.0 тэрбум төгрөгт хүрч, орон нутгийн орлогын төлөвлөгөөг 106.3 хувиар давуулан биелүүлсний үр дүнд тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүлж чадлаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон бүтээн байгуулалт болох Спортын ордон, Хүний хөгжлийн төв-Хуримын ордон ашиглалтад орж, Өндөр гэгээн Занабазарын сэрэг дүр бүхий цэцэрлэгт хүрээлэн, хүүхэд залуучуудын паркийн инженерийн шугам сүлжээ орчны тохижилт, хөл бөмбөгийн хиймэл зүлэгтэй талбай, алсыг харагч, морин тойруулга зэрэг ажлууд хийгдэв.

Бидний хийсэн ХШҮ-ний дүнгээр хөтөлбөрийн эхний 2 жилийн хэрэгжилт нийт дүнгээрээ 70.4 хувьтай гаргаснаас нийт 152 зорилт, арга хэмжээний 22.4 хувь буюу 34 зорилт, арга хэмжээ 90.0-100.0 хувь биелж, 57.2 буюу 87 зорилт нь 70.0 хувийн хэрэгжилттэй, огт хэрэгжээгүй болон 10 хувийн хэрэгжилттэй зорилт, арга хэмжээ байхгүй байна. Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилт эхний хоёр жилийн өссөн дүнгээр хангалттай хэрэгжиж байна гэсэн үг юм. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, 10000 хүн амд ногдох их эмчийн хангамжийг 17.5 промиллд хүргэх, спортын ордны барилгыг ашиглалтад оруулж, шаардагдах тоног, төхөөрөмж хэрэгслэлээр ханган байнгын үйл ажиллагаанд оруулах, баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2012 онд 60.0 хувьд хүргэх зэрэг нийгмийн салбарын зорилтуудыг 2 жилийн өмнө бүрэн хэрэгжүүллээ. Харин хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах, Арвайхээр сумын агаарын бохирдлыг багасгах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бүх сумдыг төв суурингийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох, Арвайхээр, Хархорин сумдын ерөнхий төлөвлөгөөнд шинэчлэлт хийж, суурьшлын шинэ бүс, бичил хорооллуудыг төлөвлөн, төлөвлөлттэй хэсгүүдэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, Хархорин, Хужирт сумдын төвд үерийн далан суваг барьж ашиглалтад оруулна гэсэн зорилтуудын хэрэгжилт 30.0 хувьтай байгаа нь үлдэж байгаа богинохон хугацаанд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байгаа юм.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүлгийн зорилтоор авч үзэхэд: Хүн ам, нийгмийн бодлого 70.7, эдийн засгийн бодлого 71.0, төрийн удирдлагын бодлого 69.5 хувь буюу

3 бүлэг дунджаар 70.0 орчим хувиар жигд хэрэгжиж байна гэж хэлж болох бөгөөд салбаруудаас боловсрол 88.9, эдийн засаг, төсөв санхүү, хөрөнгө оруулалт 76.7, жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ 75.0 хувиар хэрэгжиж бусад салбаруудаасаа түрүүлж байгаа нь сайшаалтай боловч хөдөлмөр эрхлэлтийн салбарын зорилт, арга хэмжээ 56.6 хувьтай байгаа нь бид ажлын байрыг нэмэгдүүлэн ажилгүйдлыг бууруулж, өрх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх гол зорилтын хэрэгжилт удааширч байгааг харуулж байна. 2010 оны 12 сард хуралдсан ээлжит ИТХуралдаанаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх тухай” дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж батлуулав.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны хэрэгжилтээр 28.0 хувь байсан бол энэ онд 2.5 дахин өссөн дүн харагдаж байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

А. ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2010 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч 11 яамны сайдаас аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ байгуулан ажиллаж, бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг дэргэдэх агентлагийн ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээнд тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон тусгаж, гэрээний биелэлтийг холбогдох агентлагуудаас гаргуулан, аймгийн Засаг даргаар хянуулж баталгаажуулан, яамдад хүргүүлэв.

Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч 11 яамны сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлт жилийн эцсээр 96.0 хувьтай, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн ерөнхий менежерүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, дундаж үнэлгээ 93.1 хувьтай дүгнэгдлээ.

ХХААХҮСайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаар хяналт-шинжилгээ хийлгүүлэн, хэрэгжилтийг үнэлүүлэх шаардлагыг тавьсан нь үр дүнгээ өгч, бодитойгоор үнэлэгдэх боломж бүрдэн, яам, аймгийн ЗДТГ-ын ажлын уялдаа холбоо сайжирч байгаа тул цаашид бусад яамдын түвшинд ч энэ чиглэлд анхаарлаа хандуулан ажиллах нь зүйтэй байна.

Яамдын сайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний үр дүнгийн үнэлгээгээр аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Тээвэр авто замын газар, Шүүхийн шинжилгээний алба, Татварын хэлтэс, Цэргийн штаб, Статистикийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг агентлагууд салбар яамандаа улсад эхний 1-5 дугаар байранд шалгарлаа.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2010 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ бүрээр боловсруулан баталж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг хуулинд заасан хугацаанд зарлаж, бараа бүтээгдэхүүн худалдан авах тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласнаар улсын төсвийн 3.1 тэрбум төгрөгийн тендерийн ажлыг гүйцэтгүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч яам, газруудын захиалгаар 2010 оны санхүүгийн жилд Өвөрхангай аймагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт

№	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	Батлагдсан төсөвт өртөг сая,төг	Гэрээний дүн
1	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	1330000.0	1231987.1
	Хөрөнгө оруулалт:	950000.0	876290.7
1	Хайрхандулаан сум 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга	350000.0	315467.3

2	Цэцэрлэгийн барилга 75 ортой /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	350000.0	318823.4
3	Уянга сумын Жаргалант багийн Соёл, спортын барилга	250000.0	242000.0
1.2	Их засвар	380000.0	355696.4
1	Төгрөг сумын ЕБС-ийн хичээлийн байрны засвар	50000.0	31696.4
2	Богд сумын ЕБС-ийн дотуур байрны засвар	70000.0	72000.0
3	Гучин-Ус сумын ЕБС-ийн хичээлийн байрны засвар	80000.0	72000.0
4	Баянгол сумын Соёлын төвийн засвар	30000.0	29000.0
5	Аймгийн ХДТ-ын барилгын их засвар	30000.0	33000.0
6	Спорт заалны барилгын их засвар	120000.0	108000.0
2	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	315000.0	292669.5
1	"Чацаргана-2" төслийг /ББУлаан, Богд, Хайрхандулаан, Бүрд, Нарийнтээл, Уянга Тарагт сумдуудад / хэрэгжүүлэх	100000.0	79669.5
2	Усалгаатай газар тариалан хөгжүүлэх төсөл	190000.0	190000.0
3	Богд сумын ундны усны зориулалтай худгийн засвар /Шүүлтүүртэй/	25000.0	23000.0
3	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	585000.0	544218.7
1	Хужирт сумын Эмнэлгийн барилгын өргөтгөл	500000.0	465000.0
2	Богд сумын эмнэлгийн барилгын засвар, худаг	85000.0	79218.7
4	ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	400000.0	398800.0
1	Арвайхээр сумын доторх хатуу хучилттай авто зам	200000.0	199000.0
2	Хархорин сумын доторх хатуу хучилттай авто зам	200000.0	199800.0
5	ШАДАР САЙД	600000.0	600000.0
1	Занабазарын нэрэмжит Цэцэрлэгт хүрээлэн	300000.0	300000.0
2	Хүүхэд залуучуудын парк байгуулах	300000.0	300000.0
	НИЙТ ДҮН	3230000.0	3067675.3

Б. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ 2010 ОНЫ БИЕЛЭЛТ

2010 оны Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг ТБУСТ хууль, Төрийн албаны тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг баримтлан нэг жилийн хугацаатай байгуулан ажиллав.

Энэхүү гэрээ нь үр дүнгийн гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүнийг төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлж өмчлөлтийн эрхийн талаарх зорилго, зорилтуудыг хангах үндсэн дээр аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно. Төсвийн ерөнхийлөн захирагчид ерөнхий менежерээс 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүнүүд нь: хууль тогтоомж, төр засгийн удирдах дээд байгууллагын бусад шийдвэрээр үүрэг болгосон ажил үйлчилгээ, байгууллагын стратегийн зорилтын дунд хугацааны хөтөлбөр төлөвлөгөөнд тухайн жилд хэрэгжүүлэхээр заасан ажил үйлчилгээ, аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тухайн жилд нийлүүлэхээр тусгагдсан ажил үйлчилгээ, дээрхээс гадна аймаг, орон нутгийн цаг үеийн зорилтыг биелүүлэх шаардлагын үүднээс тухайн жилд шинээр хийж гүйцэтгэх ажил үйлчилгээнүүдээс бүрдсэн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчид аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ерөнхий менежер нь 2010 онд нийт бүтээгдэхүүн 16, тусгай захиалгат бүтээгдэхүүн 6, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх бүтээгдэхүүн 3-ийг тус тус нийлүүлэхээр гэрээнд тусгаж дээрх бүтээгдэхүүнүүдийг тайлант жилд бүрэн биелүүлсэн байна.

Энэ нь нэгжийн менежерүүдтэй байгуулах үр дүнгийн гэрээний бэлтгэлийг сайтар хангаж, гэрээний хэрэгжилтийн явцын талаар ажил хэрэгч ярилцлагын аргыг оновчтой хэрэглэн, гэрээнд оруулах бүтээгдэхүүнийг онож сонгох замаар гэрээг үр нөлөө, үр дагаварт чиглүүлж улмаар үр дүнд чиглэсэн гүйцэтгэлийн удирдлагын арга болгон хэрэгжүүлж ажилласантай холбоотой гэж дүгнэж байна.

Тайлант онд ерөнхий менежер нь төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой стандартыг мөрдлөг болгож удирдах албан хаагчийн манлайлал, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж ажилласан гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас үнэлсэн байна.

Ийнхүү гэрээлэгч талууд гэрээгээр харилцан хүлээсэн үүргүүдээ амжилттай хэрэгжүүлснээр ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт 95.4 оноо буюу “А” үнэлгээтэй дүгнэгдэв.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

А. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, СЭЗС-ын тушаал, загвар, зааврын дагуу аймгийн ЗДТГ-ын 2011-2014 онд хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, аймгийн хэмжээнд төсвийн байгууллагуудын “Үйл ажиллагааны хэтийн /бизнес/ төлөвлөгөө” боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг бодлогоор зохион байгуулсны үр дүнд төсвийн бүх байгууллагууд хэтийн төлөвлөгөөтэй болж, байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлон үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сахилгыг сайжруулах талаар “Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар гарган хэрэгжилтийг тооцон төрийн байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, үйлчилгээний байгууллагуудын 64 дарга, эрхлэгч нарт төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр 9 төрлийн үүрэг даалгавар өгч, ажлын хариуцлага алдсан 179 төрийн албан хаагч, 4 ерөнхий менежерт сануулах, цалин, албан тушаалыг бууруулах зэрэг сахилгын шийтгэл ногдуулж, 3 албан хаагчийг төрийн албанаас халах арга хэмжээ авсан болно.

Аймгийн албан ёсны цахим хуудас /www.uvurkhangai.mn, www.uvurkhangai.gov.mn/ -ыг шинээр бий болгон орон нутгийн удирдлага, үйл ажиллагааны мэдээллийг тогтмол баяжуулан иргэдийг мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг онлайн хэлбэрээр хүргэх /архивын лавлагаа, өргөдөл санал хүсэлт хүлээн авах, нэг цэгийн үйлчилгээ гэх мэт/, нутгийн удирдлагын шийдвэр болох захирамж, албан даалгавар, тогтоол зэрэг хуулийн нэгдсэн хайлтын систем зэргээр мэдээлэл технологийн орчин үеийн шаардлагад нийцсэн веб хуудас болсон юм. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавруудыг дахин нягтлан бүртгэж хүнд суртал, чирэгдэл учруулахуйц заримыг нь хүчингүй болгож, зармыг нь шинэчлэн иргэдэд мэдээллээр үйлчлэх танхим, эрх зүйн зөвлөгөө өгөх газруудад ил тод байршуулж, хэвлэл мэдээллээр олон нийтэд нээлттэй сурталчилж байна. 2010 оны 10 сард “Нээлттэй хаалганы өдөр”-ийг аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу бүх хэлтэс, агентлагуудыг сум, багт хуваарилан 2-3 хоногийн хугацаанд хуваарилагдсан сумдад төрийн үйлчилгээ, мэдээллийг газар дээр нь шинэлэг байдлаар зохион байгууллаа. Нийт 16 хэлтэс, агентлаг 19 суманд сумын ЗДТГ, багийн Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллагууд, 86 төсөвт байгууллага, банк, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран уг нээлттэй өдөрт 7600 гаруй иргэнийг хамруулсан байна. “Нээлттэй хаалганы өдөр”-ийн хүрээнд хууль сурталчлах, төрийн үйл ажиллагаа, үр дүнг нийтэд мэдээлэх, төрөл бүрийн сургалт, үзэсгэлэн, иргэдийг сонсох цаг, урлаг, спортын арга хэмжээ зэрэг олон нэр төрлөөр явагдаж, 189 иргэний санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч 104-т нь шууд хариуг өгч шийдвэрлэв. Аймгийн “Иргэний эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж, энэ онд 11 суманд шинээр “Эрх зүйн мэдээллийн төв”-ийг 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулж, өдөр тутмын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэн орон нутагт хууль сурталчлах, гарын авлага, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Б. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Манлайллын сургалтын хөтөлбөрийн дагуу сургагч багш нар ерөнхий менежерүүдийн манлайллын 3 үе шаттай сургалтыг аймгийн ЗДТГазрын хэлтсийн дарга нар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтсийн дарга, ерөнхий менежер, Өлзийт, Баянгол, Сант, Төгрөг сумдын төсөвт байгууллагын дарга, захирал, эрхлэгч 41 нэгжийн болон ерөнхий менежерийг сургаж, Төрийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг хангах, Суралцагч байгууллага болох аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дээрх төслийн үр дүнг тайлагнах ажлын хүрээнд 2008, 2009 онд сургалтанд хамрагдаж сертификат авсан аймгийн Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга болон сумдын ерөнхий менежерүүд тус тусдаа баг болон үлгэрчилсэн 8 цагийн хичээлийг 2-3 үе шаттайгаар 7-14 хоногийн зайтай өөрсдийн сум, байгууллагын төрийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Төрийн жинхэнэ албан тушаалын 46 сул ажлын байрны мэргэжлийн шалгалтанд 166 иргэн бүртгэгдэн хамрагдснаас 29 ажлын байранд тэнцсэн 103 иргэдийг төрийн жинхэнэ албаны анх орох иргэний нөөцөд бүртгэснээс 55 иргэн төрийн жинхэнэ албан тушаалд зохих журмын дагуу томилогдов. Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтан болон төсвийн байгууллагын менежер /дарга, эрхлэгч, захирал/-ийн сонгон шалгаруулалтыг энэ онд 9 удаа зарлан явуулж, 39 иргэн хамрагдан 18 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдэн, 8 иргэн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдсон болно. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны 2008, 2009, 2010 оны нөөцөд бүртгэгдсэн иргэдээс төрийн жинхэнэ албан тушаалын болон удирдах ажилтны 70 гаруй сул ажлын байрыг нөхөж, мэдээллийн сандаа баяжилт тэмдэглэгээ тогтмол хөтөлж ил тод мэдээлж хэвшсэн.

Төрийн албан хаагчийн бүртгэл, хөдөлгөөний сүүлийн жилүүдийн тайланд дүгнэлт хийн 2010 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах талаар хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний тухай” мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлийн дарга тавьж хэлэлцүүлэн аймгийн төрийн албаны өнөөгийн байдлын тухай мэдээллийг орон нутгийн “Таны элч” сонинд нийтлүүлж, ӨВ TV-ээр сурталчлав.

Төрийн болон нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх улирлын сургалтанд тус бүр 2 төрийн албан хаагч, магистрын улирлын сургалтанд 1 удирдах ажилтан, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино хугацааны сургалтанд 2 удирдах ажилтан, 5 төрийн жинхэнэ албан хаагч хамрагдав. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын 2010 оны 318 дугаар захирамжаар сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн тогтоож, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн 33 шинэ залуу ажилтнаар төрийн албан хаагчдын нөөцийг нэмэгдүүллээ.

Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч “Суралцагч байгууллага” аймгийн хөтөлбөр, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тооцон дүгнэхэд бүрэн бус мэдээгээр төрийн албан хаагчдаас 19 ажилтан гадаадад, 466 гаруй ажилтан Улаанбаатар хотод болон бусад аймагт, 1372 шахам албан хаагчид орон нутагт зохион байгуулсан сургалтанд хамрагдан төрийн байгууллагууд төрийн албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах арга хэмжээнд 160.2-260.2 сая төгрөг зарцуулсан байна.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, цалин, нэмэгдэл, урамшууллын тухай сумын Засаг дарга, ерөнхий менежерүүдэд сургалт зохион байгуулж, төрийн жинхэнэ 77 албан хаагчдад зэрэг дэв шинээр олгох ба зэрэг дэвийг ахиулах тухай төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төрийн албан хаагчдын цалин, нэмэгдэл урамшууллын холбогдолтой хууль, тогтоол, журам, зөвлөмжийн сантай болж зөвлөмж зөвөлгөөгөөр тогтмол ханган ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сахилгыг сайжруулах талаар “Төрийн албан хаагчдын манлайлал, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2009 оны 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг тооцон төрийн байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, үйлчилгээний байгууллагуудын 64 дарга, эрхлэгч нарт төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ажлын чанар дүнг нэмэгдүүлэх чиглэлээр 9 төрлийн үүрэг даалгавар өгч, ажлын хариуцлага алдсан 179 төрийн албан хаагч, 4 ерөнхий менежерт сануулах, цалин, албан тушаалыг бууруулах зэрэг сахилгын шийтгэл ногдуулж, 3 албан хаагчийг төрийн албанаас халах зэрэг арга хэмжээ авсан болно.

В. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Төсвийн төслийг төсөвт байгууллага бүрийн хэтийн \бизнес\ төлөвлөгөөг үндэслэн тухайн байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрт суурилсан байдлаар боловсруулж байгаа бөгөөд төсвийн гүйцэтгэл болон батлагдсан төсвийг байгууллагын вэб сайтад байрлуулан олон нийтэд мэдээлж байна. Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, хагас бүтэн жилийн тайланг байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт тогтмол байрлуулж, төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтанд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавих боломжийг бүрдүүлж байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсвийн тодотголийн талаархи мэдээллийг байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт байрлуулж иргэд байгууллага мэдээллийг чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлж байна.

Хууль болон засгийн газрын тогтоолоор батлагдсан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч байгаа бөгөөд “Нэг цэгийн үйлчилгээ”-г нэвтрүүлснээр иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмж дээшилж байна.

Г. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 2010 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 510.6 сая төгрөгийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3045.7 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 510.6 сая төгрөгийн хөрөнгөөр нийт 12 удаагийн худалдан авалт хийснээс 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулах журам, 1 ажлыг хязгаарлагдмал тендер шалгаруулах журам, 8 ажлыг харьцуулалтын аргаар гүйцэтгэгч байгууллагыг сонгож гэрээ хийсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3045.7 сая төгрөгөөр төлөвлөгөөний дагуу нийт 18 удаагийн худалдан авалт хийснээс “Нээлттэй тендер шалгаруулалт”-ын журмаар 13 ажил, хязгаарлагдмал тендер шалгаруулах журмаар 1 ажил, харьцуулалтын аргаар 4 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулав. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 418 дугаар тушаалын дагуу тендерт оролцогчоос зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавигдах шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгаж тендерт оролцох хүсэлтэй бүх этгээдэд нээлттэй, ил тод олгож ажиллав.

Зарим салбарын худалдан авах ажиллагааг илүү ил тод нээлттэй болгохын тулд жил бүр төрийн болон төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн хамтарсан гурван талт түншлэл зөвлөгөөнийг зохион байгуулж, тухайн салбарт худалдан авах бараа, ажил үйлчилгээг нээлттэй зарлаж, орон нутгийн иргэдийг тендерт өргөн оролцох, тендерийн материал бэлтгэх талаар сургалтанд хамруулан тендерийг нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог төрийн бус байгууллагуудын төлөөлөл илүүтэйгээр бүрдүүлэн тухайн бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь орон нутгийн бизнесийг дэмжихэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Тус аймагт Боловсрол, Эрүүл мэндийн салбарт нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах, Арвайхээр сумын боловсролын салбарын үдийн цай хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэх худалдан авах ажиллагааг дээрх байдлаар зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж хэвшсэн нь төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн зүгээс ихээхэн сайшаагдсан болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг улирал бүр төсвийн асуудал эрхэлсэн төрийн Захиргааны төв байгууллагад тайлагнаж байна. Үүний зэрэгцээ худалдан авах ажиллагааг илүү ил тод, нээлттэй явуулах үүднээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд байнга тайлагнаж хэвшлээ.

Энэ нь иргэдэд зөв мэдээллийг цаг ту жй бүрт хүргэж, бараа ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж иргэдийн дунд элдэв төрлийн цуу яриа, хардлаг сэрдэлт, бухимдлыг бий болгодог явдлыг таслан зогсоох үндсэн арга хэрэглэгдэхүүн болж байна. Төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН-гийн дарга, нягтлан бодогч нарт худалдан авах ажиллагааны талаарх сургалтыг

зохион байгуулж худалдан авах ажиллагааг илүү ил тод, нээлттэй явуулах талаар мэргэжил, арга зүйн туслалцааг байнга үзүүлж байгаа нь худалдан авах ажиллагааны чанар, ил тод, нээлттэй байдалд эерэг нөлөө үзүүлж байна.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

А. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2010 оны гүйцэтгэлийг 51 үзүүлэлтээр гаргалаа. Үүнд: эдийн засгийн гүйцэтгэлийг 19 үзүүлэлтээр, нийгмийн хөгжлийн биелэлтийг 19 үзүүлэлтээр, хөгжлийн гүйцэтгэлийг 11 үзүүлэлтээр тус тус гаргаж, албан ёсны статистикаар гардаггүй нилээд үзүүлэлтийг холбогдох хэлтэс, албадын захиргааны мэдээллээс гаргуулан авлаа.

Таримал ойн амьдралтад цаг уурын дулаарал, хуурайшилт, ойжуулалтын ажлын нормативт зардал хэт бага байгаа зэрэг хөндлөнгийн хүчин зүйлийн улмаас таримал ойг тогтоосон цаг хугацаанд нь улсын ойн санд шилжүүлэх ажил хүндрэлтэй байна. Үүний улмаас аж ахуйн нэгжүүд таримал ойг улсын ойн санд шилжүүлэх хугацааг хойшлуулах, нэмж нөхөн тарилт хийх гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа учир журамд байгаа “Улсын ойн санд хүлээж авсан талбайн хэмжээ” гэдэг заалтыг жил бүр дүгнэх боломжгүй байгааг харгалзан үзэж хасах эсвэл тооцох боломжгүй гэсэн саналтай байна. 2009, 2010 онд гүйцэтгэлийг дүгнээгүй болно.

Аймгийн дотоодын нийт бүтээгдхүүний жинхэнэ гүйцэтгэл тооцох хугацаа болоогүй бөгөөд урьдчилсан байдлаар гаргалаа. Аймгийн дотоодын нийт бүтээгдхүүний 70.0 -аад хувийг ХАА-н салбар эзэлдэг. 2010 онд мал сүргийн 45.0 хувь нь хорогдсонтой холбоотойгоор нийт бүтээгдэхүүн буурах урьдчилсан тооцоо байна.

Ядуурлын түвшинг орон нутагт тооцох нэгдсэн аргачлал байхгүй ба сумдын өөрсдийнх нь гаргаж ирүүлсэн мэдээгээр хавсралтад орууллаа.

Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцааг ҮСХ-оос түүвэр судалгааны дүн мэдээг үндэслэн улсын дүн болон бүсчилсэн байдлаар 2-р улиралд гаргадаг ба аймгийн хувьд бүсчилсэн байдлын дүн мэдээтэй уялдуулан урьдчилсан байдлаар гаргалаа. Бусад үзүүлэлтийн хувьд 2010 оны гүйцэтгэлээр гаргалаа.

Б. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Нийт түүврийн аргаар авсан 1600 гаруй иргэдээс сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүн, өрхийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлт, ажилгүйдэл ядуурлыг бууруулж, амьжиргааг дээшлүүлэх, багш нарын ур чадвар, сумын бүтээн байгуулалт, байгууллагуудын тохижилт гэсэн асуултанд хангалттай хэмээн хариулсан байна.

2010 онд аймгийн хэмжээнд бүтээн байгуулалт, орчны тохижилтын жил болгон зарлаж, бүтээн байгуулалтыг төрийн болон бизнесийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүд идэвх санаачлагатай өрнүүлж ажилласан. Бүтээн байгуулалт, орчны тохижилтын ажлыг иргэд ихээхэн дэмжиж /84.5%/, багш нарын ур чадвар, харилцаа, нэр хүндийг дээшлүүлэхэд улсын хэмжээнд анх удаа нэгдсэн стандартын дагуу аттестатчилах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сурлагын амжилт, багшийн ёс зүйд анхаарсан нь /81.2%/ үр дүнгээ өгч, урьд оноос иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ өссөн бөгөөд орон нутагт иргэдийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэх, хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих асуудал бүх сумдын иргэдийн дундах нийтлэг тулгамдсан асуудал хэвээр байна.

Харин төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүй, харилцаа, байгаль орчны нөхөн сэргээлт, хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгаажилт, тээвэрлэлтэнд хангалтгүй буюу мэдэхгүй хэмээн хариулсан байна. Мөн Богд, Төгрөг, Бүрд, Баруунбаян-Улаан зэрэг сумдад хууль тогтоомж сурталчлах, иргэдэд төрийн үйл хэргийг мэдээлэх, төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, ур чадварыг дээшлүүлэхэд хангалтгүй байгааг илүүтэй харуулсан байна.

Дээрх санал хүсэлтийг сумд, агентлагуудыг жилийн эцэст тусгай удирдамжийн дагуу хийгддэг хяналт – шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгүүд өөрсдийн төлөөлөл, сум, агентлагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн хамтаар биечлэн санал хүсэлтийг цуглуулан дүгнэдэг бөгөөд тухайн жилдээ зохион байгуулагдсан аймгийн Засаг даргын албан даалгаврын хүрээнд иргэдээс сэтгэл ханамжийн асуумж авах, нээлттэй

хаалганы өдрийн үеэр сэтгэл ханамжийн судалгаа зэргийг жилийн эцэст нэгтгэн үнэлж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлдэг юм. Үүнд: тухайн сумд болон хэлтэс, агентлагуудын талаарх хэрэглэгчдийн үнэлгээг дүгнэж, үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт, үр дагаврын гол үзүүлэлт болгон байр эзлүүлэн шагнаж урамшуулах, эргэн мэдээлэх, тулгамдсан асуудлын талаарх бодлого, шийдвэр, зөвлөмжөөр хангах зэрэг олон арга хэмжээг зохион байгуулдаг.

Дээрх асуумжийг хангалттай, хангалтгүй, мэдэхгүй гэсэн хялбар, иргэдэд ойлгомжтой, нэгтгэхэд хялбар байх хэлбэрээр боловсруулан асуудал тус бүрээр сумд, агентлагуудад нэгтгэн дүгнэснээр энэ онд юунд анхаарах, тухайн жилийн бодлого зорилттой уялдуулах зэргээр үйл ажиллагаандаа ашиглаж байна. Асуулгад оролцсон иргэд бодол, дүгнэлт, санал хүсэлтээ тодотгон бичих нээлттэй асуултанд хариулсан байдлаас дүгнэлт хийж үнэлгээ өгөхөд:

1. Та өөрийн сумыг хөгжүүлэхэд юунд анхаарах хэрэгтэй гэж боддог вэ?

Сум орон нутагт ажиллах орчин бүрдүүлэх, тогтмол орлоготой болгох, төрийн албан хаагчид болон бусад иргэд орон сууц, байраар хангах, жижиг дунд үйлдвэрлэл, зээлийн баталгааг бүрдүүлэхэд анхаарахыг дийлэнх хувь хэлсэн байна. Иргэд урьд оноо бодвол төрөөс тодорхой хэмжээний мөнгийг бэлнээр авч амьжиргаагаа залгуулж байгаа хэдий ч барааны болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг төрөөс зохицуулж болох эсэхэд анхаарсан байна. Энэ онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээл, хүнсний бүтээгдэхүүний баталгаажилт, чанар аюулгүй байдалд анхаарч холбогдох шийдвэрийг хэрэгжүүлж эхэллээ.

2. Төрийн албан хаагчдын ажлын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх талаар саналаа бичнэ үү?

Төрийн албан хаагчид хүнд суртал, иргэдийг чирэгдүүлэх, харьцааны соёл хангалтгүй, ёс зүйн хувьд төрийн чиг үүргийг гүйцэтгэхэд мэдлэг, ур чадвар, санаачлага, ажлын хариуцлага тэр дундаа ажлын цаг ашиглалт хангалтгүй байна гэсэн байна. Иймд 2011 оныг Төрийн албаны зөвлөлөөс зарласан “Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх” жилийн хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, бүх шатны удирдлагуудад үүрэг даалгаврыг өгөн ажиллаж байна.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА** **Д.БАЯРТОГТОХ**